Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Г.Энхмаа, чанарын хяналтын менежер Р.Алтанцэцэг, аудитор Г.Бэлэгт, туслах аудитор Я.Чинцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хавдар судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/92 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хорт хавдар өвчний тархалтын түвшинг тогтоох
 - ✓ Хорт хавдар өвчний тархалтын түвшинг тогтоох
 - ✓ Хорт хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх
 - ✓ Хорт хавдар өвчнийг илрүүлэх
 - ✓ Хорт хавдар өвчнийг оношлох
 - ✓ Хорт хавдар өвчнийг эмчлэх үйл ажиллагаа
- Байгууллагын тодорхойлж баталгаажуулсан үндсэн болон туслах үйл ажиллагааны чиг үүрэг
 - ✓ Хавдрын чиглэлийн төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдвар/ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоол “Коронавируст халдвар/ковид-19/-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хавдар судлалын үндэсний төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус төвийн дотоод аудитор нь байгууллагын стратеги зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэхийн тулд 2020 онд өндөр эрсдэлтэй 3, дунд эрсдэлтэй 5, бага эрсдэлтэй 10, бүгд 18 ажил хийхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна. Санхүүгийн үйл ажиллагаанд 9 ажил хийхээр төлөвлөж 6 аудитын ажлыг гүйцэтгэж 3 зөвлөмж өгсөн байна. Худалдан авалтын ажиллагаатай холбоотой 7 ажил төлөвлөж 6 ажлыг гүйцэтгэн дүгнэлт тайлан гаргаж холбогдох ажилтнуудад танилцуулжээ. Мөн Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, журам, Эрүүл мэндийн сайдын тушаал, журмын хэрэгжилт, төвийн ерөнхий захирлын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд аудит хийхээр 2 ажил төлөвлөж гүйцэтгэн зөвлөмж өгчээ.

Дотоод аудитор нь мэдээллийн ил тод байдлын хүрээнд 2020 оны шилэн данс болон байгууллагын цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь болон үнэн зөв оруулах байдалд хяналт тавьж зөвлөмж өгч ажиллаж иржээ

Хавдар судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг гүйцэтгэлийн үе шатанд дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 29,152,660.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 291,526.6 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 33,302,666.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 333,302.7 мянган төгрөгөөр тодорхойлов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хавдар судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,808,663.4 мянган төгрөгөөр буюу 20.86 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын данс 827,842.6 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн данс 7,911,030.6 мянган төгрөгөөр өсөж материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,523.3		-5,523.3
Авлага	15,582.4	90,895.9	75,313.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,753,210.0	2,581,052.6	827,842.6
Үндсэн хөрөнгө	40,465,801.1	48,376,831.7	7,911,030.6
Нийт хөрөнгө	42,240,116.8	51,048,780.2	8,808,663.4

Өр төлбөр	5,792.0	10,936.0	5,144.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	42,234,324.8	51,037,844.2	8,803,519.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	42,240,116.8	51,048,780.2	8,808,663.4

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй болж 5,523.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд замд яваа мөнгөн хөрөнгө үлдэгдэлгүй болсноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл татаас санхүүжилтийн авлага 80,363.5 мянган төгрөгөөр өсөж 90,895.9 мянган төгрөг болсон байна. Авлага дансны үлдэгдэлд урьд онуудад үүссэн, он удаан жил болсон барагдах боломжгүй эрсдэлтэй авлагагүй байна.

Бараа материалын данс 2,581,052.6 мянган төгрөг болж 827,842.6 мянган төгрөгөөр өссөн байна. Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 44,174.3 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 17,068,957.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, байгууллага, хувь хүмүүсээс 159,912.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал хандиваар авч нийт 17,273,044.2 мянган төгрөгийн бараа материал нэмэгджээ. Мөн тус данснаас 16,065,051.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/38 тоот тушаалаар 145,836.2 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, мөн Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/102 тоот тушаалаар 234,314.3 мянган төгрөгийн хангамжийн материал акталж нийт 16,445,201.6 мянган төгрөгийн зарлага гарчээ.

Бараа материалын “Аж ахуйн материал” дансанд 2014 онд хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 21,062.0 мянган төгрөгийн 2 нэр төрлийн удаан хугацаанд ашиглагдаж байгаа цаашид ашиглагдах хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнээс 5,430.0 мянган төгрөгийн элэг шилжүүлэн суулгах програм ашиглалтгүй байгаа бөгөөд цаашид ашиглах боломжгүй, технологийн хоцрогдолд орж шаардлага хангахгүй болсон байна.

Үндсэн хөрөнгийн данс нь барилга байгууламжийг урсгал төсвийн санхүүжилтээр капиталжуулснаар 2,024,007.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 868,392.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар **8,875,382.8** мянган төгрөг, хандив тусламжаар 734,896.6 мянган төгрөг, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/38 тоот тушаалаар дотооддоо бараа материал, хангамжийн данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн 145,836.2 мянган төгрөг бүгд 12,648,515.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Мөн Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/38 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн данс хооронд **8,995,622.1** мянган төгрөгийн хөрөнгийн шилжүүлэлт хийжээ.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 37,900.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 8,049,658.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 312,914.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 474,909.9 мянган төгрөгийн барилга байгууламжийн сайжруулалт хийгдэж нийт **8,875,382.8** мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 671 тоот тогтоолоор акталсан 3,023,203.7 мянган төгрөг, тайлант оны элэгдлийн зардал 13,427,717.3 мянган төгрөг, бүгд 25,446,543.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагджээ.

Үүнээс биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 2,165,900.5 мянган төгрөгөөс 2,033,455.4 мянган төгрөг болж 132,445.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгө нь урсгал төсвийн худалдан авалтаар 47,650.0 мянган төгрөг, дотооддоо үндсэн хөрөнгийн данс хоорондын шилжүүлгээр 226,050.0 мянган төгрөг бүгд 273,700.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн 239,759.7 мянган төгрөгийн хөрөнгийг

акталж данснаас хасан, элэгдлийн зардалд 166,385.4 мянган төгрөг тооцож нийт 406,145.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,936.0 мянган төгрөг болж 5,144.0 мянган төгрөгөөр өссөн нь 2 байгууллагын түрээсийн барьцаа байршуулснаас 3,880.0 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй 5 гүйлгээний улмаас 7,056.0 мянган төгрөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл байхгүй.

Бусад 7,056.0 мянган төгрөгийн өр төлбөр нь Мобинет ХХК-тай холбоотой 497.6 мянган төгрөг, Сувд-Очир налайх ХХК-тай холбоотой 4,050.0 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх үзлэгт ажилласан эмч ажиллагсдын урамшууллын 908.4 мянган төгрөг, давсан орлогын урамшууллын 1,600.0 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээний улмаас харилцах дансанд буцаж орсноос үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 51,037,844.2 мянган төгрөг болж 8,803,519.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар, хандив тусламжаар, үнэ төлбөргүй шилжүүлэлтээр үндсэн хөрөнгө 21,644,137.5 мянган төгрөгөөр, бараа материал 204,086.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 42,106,185.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 1,525,701.0 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дараах орлого байна. Үүнд: Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 8,729,367.4 мянган төгрөгөөр буурсан, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 2,833,213.5 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 4,421,006.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 4,150.0 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд цалингийн зардал 867,589.2 мянган төгрөг, эмийн зардал 1,359,082.8 мянган төгрөг, урсгал засварын зардал 697,194.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 32,603,487.6 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 71,456.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 32,674,943.7 мянган төгрөгөөр баталсан нь өмнөх оны баталсан төсвөөс 8,129,960.0 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь эмнэлгийн үйл ажиллагааг өргөтгөх зорилготойгоор Энэр мед ХХК-ийн эмнэлгийн барилгыг түрээслэн “Б” корпус хэлбэрээр ашиглахад зориулан 6,650,048.0 мянган төгрөгийг 2020 оны төсөвт нэмж баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 76 арга хэмжээг санхүүжүүлэхээр 32,674,943.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 15,465,608.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 12,641,432.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 4,567,902.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр оны эхэнд байсан замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,523.3 мянган төгрөг, улсын төсвөөс 15,464,148.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 12,077,195.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 4,434,175.8 мянган төгрөг, нийт 31,981,043.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 31,975,108.3 мянган төгрөгийг зарцуулж 5,935.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 31,975,108.3 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 162,702.8 мянган төгрөгөөр, байрны түрээсийн зардлыг 144,344.9 мянган төгрөгөөр, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 237,321.0 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 129,985.6 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Энэ нь Энэр мед ХХК-ийн эмнэлгийн байрыг түрээслээгүй улмаас төсөвт нэмэгдэж тусгагдсан зардлууд хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Тус төвийн хувьд Б корпус болгох барилгыг түрээслээгүй ч, үйлчилгээ үйл ажиллагаа нэмэгдэхийн хирээр урсгал зардал, бусад үйл ажиллагаатай холбоотой зардлууд өссөн байна. Ковид цар тахлын улмаас тодорхой хэмжээний орлогыг олж чадаагүйн улмаас үйл ажиллагааг өргөтгөхтэй холбоотой төсөвлөгдсөн зардлуудыг зохих хууль, журмын дагуу зардал хооронд шилжүүлэн зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 34,885.1 мянган төгрөг, гадаад төсөл хөтөлбөрөөс 116,215.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 117,313.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 69,354.1 мянган төгрөг нийт 337,767.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ажлын хөлс, урамшуулалд 146,493.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 7,241.1 мянган төгрөг, нормативт зардалд 1,635.0 мянган төгрөг, эд хогшил, тоног төхөөрөмж, урсгал засварын зардалд 50,530.7 мянган төгрөг, дотоодын албан томилолтын зардалд 18,700.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 450.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 26,369.6 мянган төгрөг бүгд 251,419.5 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 86,348.3 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Резидент эмчийн зардлын орлого зардлыг тодруулбал: Урьд оны зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсвөөс буцаан авсан 4,534.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс санхүүжилт 8,390.4 мянган төгрөг, резидент эмч нараас сургалтын төлбөрт төлсөн 28,173.6 мянган төгрөг нийт 41,098.2 мянган төгрөгийн орлого орж резидентийн өрөөний засварт 23,426.0 мянган төгрөг, резидентийн сургалтын багш нарын урамшуулалд 12,664.5 мянган төгрөг, сургалтын дэвтэр гарын авлага диплом хэвлүүлэх зардалд 1,643.9 мянган төгрөг нийт 37,734.4 мянган төгрөгийг зарцуулж 3,363.8 мянган төгрөг нь үлджээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс хугацаандаа байршуулсан 21 мэдээлэл, хоцроосон мэдээлэл байхгүй, байршуулах хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмж, 153,241.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Акт				
Албан шаардлага	1	153,241.8	1	153,241.8
Зөвлөмж				
Нийт дүн	1	153,241.8	1	153,341.8

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 145,605.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 145,605.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

- Ковид-19 цар тахалтай холбогдсон хөл хорионоос үүдэн хатуу хөл хориог олон хоногоор тогтоосны улмаас завсрын аудит хийх боломж байгаагүй учраас эм, бэлдмэлийн зарцуулалтыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх .

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1.Зардлын данстай холбоотой асуудал

- 4.1.1 Илрүүлэлт Цалин, нэмэгдэл, урамшууллын тооцооллыг анхан шатны баримт, холбогдох тушаал шийдвэрийг баримтлан хөөн шалгахад:
Илүү цагийн хөлсийг тооцохдоо 1 цагийн үнэлгээг сар бүрийн ажлын тухайн хоногоор тооцохгүй бүх саруудыг 22 хоногтойгоор 176 цагаар тооцсон.
Мөн илүү цагийн хөлсийг 2 дахин тооцсон зөрчлүүд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, 53.2, 54.1 дүгээр заалтыг зөрчиж байна.
- 4.1.2 Эрсдэл: Хууль, журмыг баримтлахгүйгээр тооцоог буруу бодсоноос илүү цагаар ажилласан хүмүүст цалин хөлсийг илүү, дутуу олгох, төсвийг үр ашиггүй зарцуулах
- 4.1.3 Өгсөн зөвлөмж: Илүү цагийг сар бүрийн ажлын хоног, цагаар тооцох, илүү цагийн хөлсийг хөдөлмөрийн хуулийн 53.1 дүгээр заалтыг баримтлан тооцож олгох. Цаашид Хөдөлмөрийн хуулийн 53.2, 54.1 дүгээр заалтын дагуу хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах
- 4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу алдааг залруулж ажиллана.

4.2. Дотоод хяналттай холбоотой асуудал

- 4.2.1. Илрүүлэлт: Касст бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байж, бэлэн мөнгийг хууль журмын дагуу өдөр тутамд нь тушаагаагүй мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна.
- 4.2.2. Эрсдэл: Холбогдох дүрэм журмыг мөрдөөгүйгээс бэлэн мөнгөний ашиглал гарах, алдаж үрэгдүүлэх.
- 4.2.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 12дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" заалтыг мөрдөх
- 4.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу дотоод хяналтын ажлаа сайжруулан алдааг залруулж ажиллана.

4.3. Шилэн данстай холбоотой асуудал

- 4.3.1. Илрүүлэлт: Эм Би Би Импекс ХХК-тай 2020 оны 6 дугаар сарын 12-нд байгуулсан 65,930.0 мянган төгрөгийн гэрээний хуулбарыг шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 9-р хавсралтад цахимаар байршуулаагүй байна.
- 4.3.2. Эрсдэл: Холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчих
- 4.3.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолын хавсралт, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 4-р зүйлийн 1.12-т "цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт 7 хоногийн дотор энэхүү журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар, PDF, EXCEL, XML форматаар" гэсэн заалтыг мөрдөх
- 4.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Холбогдох хууль журмын дагуу ажиллана.

4.4. Худалдан авалт болон гэрээний хэрэгжилтийн биелэлттэй холбоотой асуудал

- 4.4.1. Илрүүлэлт: Эм Би Би Импекс ХХК-тай 2020 оны 1 дүгээр сарын 10-нд байгуулсан 25,091.7 мянган төгрөгийн цэвэрлэгээ үйлчилгээний материал худалдан авах гэрээ хийхдээ ТБОНӨХБАУХА тухай хуулийн 34.1.7 г баримталж гэрээ хийсэн
- 4.4.2. Эрсдэл: Гэрээ хийх үндэслэлийг зөв сонгож гэрээ хийгээгүйгээс гэрээ хүчин төгөлдөр бус болох
- 4.4.3. Өгсөн зөвлөмж: ТБОНӨХБАУХА тухай хуулийн 34.1.7-д "хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол" гэж заасан. Иймд цаашид гэрээ байгуулахдаа хууль тогтоомжинд нийцсэн гэрээ байгуулж худалдан авалтын ажиллагааг зохион байгуулж ажиллах
- 4.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

4.5. Зардлын данстай холбоотой асуудал

- 4.5.1. Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас гарч буй төсөл үйл ажиллагааны 33,521.5 мянган төгрөгийн зардалд мөнгөн урьдчилгааны тайлан бичээгүй, бүрдүүлсэн баримтууд санхүүгийн баримтын шаардлага хангахгүй байна.
- 4.5.2. Эрсдэл: Холбогдох хууль, дүрэм зөрчигдөх
- 4.5.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг мөрдөх
- 4.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

4.6. Үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал

- 4.6.1. Илрүүлэлт: Аж ахуйн материалын дансанд 2014 оноос хойш олон жил үлдэгдлээр бүртгэлтэй байгаа удаан хугацаанд ашиглах зориулалт бүхий 21,062.0 мянган төгрөгийн хөрөнгө байна. Үүнд:
1. Элэг шилжүүлэн суулгах програм 5,430.0 мянган төгрөгний үнэ бүхий 1 ширхэг
 2. Автомат тариур нэг бүр нь 977.0 мянган төгрөгний үнэ бүхий 16 ширхэг бүгд 15,632.0 мянган төгрөг.
- 4.6.2. Эрсдэл: Холбогдох стандарт, дүрэм журмыг зөрчих
- 4.6.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС-12, УСНББОУС-17, НББОУС-38 стандартыг мөрдөж, Сангийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 5 дугаар хавсралтын дагуу ангилан бүртгэх
- 4.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү? Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье!

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хавдар судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2020/62/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хавдар судлалын үндэсний төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалин, нэмэгдэл, урамшууллын тооцооллыг анхан шатны баримт, холбогдох тушаал шийдвэрийг баримтлан хөөн шалгахад: Илүү цагийн хөлсийг тооцохдоо 1 цагийн үнэлгээг сар бүрийн ажлын тухайн хоногоор тооцохгүй бүх саруудыг 22 хоногтойгоор 176 цагаар тооцсон. Мөн илүү цагийн хөлсийг 2 дахин тооцсон зөрчлүүд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, 53.2, 54.1 дүгээр заалтыг зөрчиж байна.	0	Зөвлөмж өгөх	Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэхүү Ц.Энхээ
2	Кассандаа бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байж, бэлэн мөнгийг хууль журмын дагуу өдөр тутамд нь тушаагаагүй мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна.	0	Зөвлөмж өгөх	Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэхүү Ц.Энхээ
3	Эм Би Би Импекс ХХК-тай 2020 оны 6 дугаар сарын 12-нд байгуулсан гэрээний хуулбарыг шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 9-р хавсралтад цахимаар байршуулаагүй байна.	65,930.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэхүү Ц.Энхээ
4	Эм Би Би Импекс ХХК-тай 2020 оны 1 сарын 10-нд байгуулсан	25,091.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий захирлын үүргийг түр	

	25,091.7 мянган төгрөгийн цэвэрлэгээ үйлчилгээний материал худалдан авах гэрээ хийхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.1.7-д "хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол" гэсэн заалтыг баримталж гэрээ хийсэн			орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэхүү Ц.Энхээ
5	Нэмэлт санхүүжилтийн данснаас гарч буй төсөл үйл ажиллагааны зарим зардлуудад мөнгөн урьдчилгааны тайлан бичээгүй, бүрдүүлсэн баримтууд санхүүгийн баримтын шаардлага хангахгүй байна.	33,521.5		Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэхүү Ц.Энхээ
6	Аж ахуйн материалын дансанд 2014 оноос хойш олон жил үлдэгдлээр бүртгэлтэй байгаа удаан хугацаанд ашиглах зориулалт бүхий 21,062.0 мянган төгрөгний хөрөнгө байна. Үүнд: 1. Элэг шилжүүлэн суулгах програм 5,430.0 мянган төгрөгний үнэ бүхий 1 ширхэг 2. Автомат тариур нэг бүр нь 977.0 мянган төгрөгний үнэ бүхий 16 ширхэг бүгд 15,632.0 мянган төгрөг.	21,062.0		Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэхүү Ц.Энхээ
ДҮН		145,605.2			

